



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/08

Мандалговь

Үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2 дахь заалт, Засгийн Газрын 2023 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 442 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам батлах тухай” 301 дүгээр тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны “Аргачлал батлах тухай” 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: Ж.Шинэ-Уянга (Захиргаа аж ахуйн албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Дэлгэрмандах (Хүний нөөц, сургалт, сурталчилгаа тайлан, мэдээ, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Батбилэг (Мал үржлийн албаны дарга)

Б.Цэрэнханд (Үйлдвэр, худалдаа


үйлчилгээний албаны дарга)

Н.Болормаа (Хүнсний хяналтын улсын байцаагч)

Б.Батгэрэл (Мал үржүүлэг, технологийн ажил

үйлчилгээний хяналтын улсын байцаагч)

2. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг журмын дагуу бодитой үнэлж, үнэлэхийг үнэлгээний баг (Ж.Шинэ-Уянга), гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ



000001033